



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЛУУС СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/27

Цагаан-Овоо

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.7, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр санхүүжих шууд худалдан авах төсөл хөтөлбөр арга хэмжээнүүдийг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Доржханд (Санхүү албаны дарга)

Гишүүд:

Х.Адъяасүрэн (Суварга багийн Засаг дарга)

Б.Шинэтулга (Наран багийн Засаг дарга)

П.Тогосмаа (Буянт багийг Засаг дарга)

С.Отгонсүрэн (Хөдөө аж ахуйн тасгийн, жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн)

2. Шууд худалдан авах төсөл хөтөлбөр арга хэмжээг сонгон шалгаруулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон холбогдох журмын дагуу хэлэлцэж шийдвэрлэхийг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ӨЛЗИЙХИШИГ

4823010053